

Нийт өргөдөл, гомдлын агуулга, бүтэц, чиг хандлага, шийдвэрлэлтийн чанар байдал, өргөдөл гомдолд тусгагдсан асуудлуудыг байгууллагаас явуулах бодлого, авах, арга хэмжээнд тусгасан байдалд судалгаа, дүн шинжилгээ хийсэн танилцуулга

Дотоод аудитын мониторингийн газраас тус газарт ирүүлсэн судалгааны дагуу 2024 оны 09 сарын 01-ээс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацаанд ажил олгогч, даатгуулагчаас ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг шалган үзлээ.

Дээрх хугацаанд Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, шимтгэл төлөлт болон нөхөн төлүүлэхтэй холбоотой 5, Сайн дурын даатгалын гэрээ, төлөлт ногдуулалтай холбоотой 14, Тэтгэврийн тогтоолт, олголт, өөрчлөлттэй холбоотой 1, Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн тогтоолт, олголттой холбоотой 1, Ажилгүйдлийн тэтгэмж тогтоолт, олголттой холбоотой 1, Даатгуулагчийн төрөл, цалингийн залруулга хийлгэхтэй холбоотой 3, Овог нэр, регистрийн дугаарын өөрчлөлт, регистрийн дугаар нэгтгэхтэй холбоотой 1, Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголттой холбоотой 13, Сайн дурын даатгал, мөн шимтгэлийн буцаалттай холбоотой 3 нийт 42 өргөдлийг хүлээн авснаас 40 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 2 өргөдлийн шийдвэрлэх хугацаа болоогүй захиргаа, хяналтын хэлтэст хянагдаж байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг харьяа нэгж хэлтэст шилжүүлэн Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох бусад хууль, журам зааварт нийцүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.



Өргөдөл гомдлын төрлөөс авч үзэхэд иргэдээс ирүүлсэн өргөдлийн 44 %-ийг Сайн дурын даатгалын гэрээ, төлөлт ногдуулалтай холбоотой өргөдөл давамгайлж байгаа бол Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголттой холбоотой 41% -ийг тус тус эзэлж байна.

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР